

## Клубын тухай ойлголт

Манай улсад маш олон клуб байдаг боловч өнөөг хүртэл үүний талаар тодорхой ном зохиол, эрдэм шинжилгээний бүтээл туйрвагдаагүй. Иймд бид клубын талаар өгүүлэхийг зорьлоо. Өнөө үед хүний хөгжил гэдэг асуудал хурцаар тавигдаад байгаа юм. Энэхүү хөгжил гэдэг асуудлыг шийдэх нэг гарц нь клубын систем юм. Цахим мэдээллийн нэвтэрхий толь википедиад **“Клуб гэдэг нь хүсэл сонирхлоороо нэгдсэн хоёр буюу түүнээс дээш хүмүүсийн нэгдлийг хэлнэ”** гэж тодорхойлсон байна. Мөн англи хэлнээс монгол хэлэнд цугларалт хэмээн буудаг. Үүнээс үзэхэд клуб нь хоёроос дээш хүмүүсийн цугларалтыг хэлдэг гэж ойлгож болохоор байна. Клубын бусад байгууллагуудаас ялгагдах гол шинж нь сонирхол дээр суурилсан цугларалт юм.

Клуб гэдэг нэр томъёо анх эртний грекийн “Солоны хууль” сурвалжид дурьдагддаг. Улмаар 17-р зууны үед клуб Английн Coffeehouse гэдэг ойлголтоор төсөөлөгдөж байсан юм. Улмаар сонгодог утгаараа 18, 19-р зууны үеэс хөгжсөн.

**Клуб нь сонгодог утгаараа бол ямар нэгэн сонирхолд суурилсан хүмүүсийн зохион байгуулалттай сонирхлын бүлэг юм.**

Бид клубын олон төрлийг мэддэг. Жишээ нь: Диско клуб, сургуулийн клуб, спортын клуб, урлагын клуб гэх мэтчлэн. Гэвч түүнийг

**а. Нийгэмд үйлчилдэг**

**б. Гишүүдэд үйлчилдэг** гэж ангилдаг.

**а. Нийгэмд үйлчилдэг клубт:** Нийгмийн сайн сайхны төлөө үйлчилдэг клубууд, бүс нутгийн байгаль хамгаалах клубууд гэх мэтчлэн санхүүжүүлэлтэй дэмжигчдээс цуглуулдаг клубууд багтдаг.

**а. Гишүүдэд үйлчилдэг клубт:** Спорт клубууд, диско клубууд, цуглуулагчдын клуб, сургуулиудын төрөл бүрийн клубууд, урлагын клубууд, чөлөөт цагаа өнгрөөх клубууд, номын клубууд гэх мэтчилэн санхүүжилтээ гишүүдээсээ цуглуулдаг клубууд багтдаг.

## **- Клуб байгуулах:**

**Клубыг сонирхол дээр нэгдсэн 2 буюу түүнээс дээш хүн байгуулдаг. Клуб нь тухайлсан зорилготой, үйл ажиллагааны хүрээтэй, тодорхой бүтэц бүрэлдэхүүтэй, гишүүнчлэлээ нэмэх эрмэлзлэлтэй байх ёстой. Жишээ нь: нэг сургуулийн 2 найз мэргэжилийнхээ сонирхолоор сургууль дээрээ клуб байгуулж сургуулийнхаа нийгмийн хичээлдээ сонирхолтой сурагчидыг нэгтгэн нийгмийн багшаатайгаа 7 хоногт нэг удаа цуглаж мэдлэгээ хуваалцах клуб байгуулах.**

**Клубын хөгжих зарчим нь “Миний мэддэгийг та бүхэн мэдэхгүй, та бүхний мэддэг зүйлийг би мэдэхгүй” гэсэн энгийн л өгүүлбэрт оршино. Жишээ нь надад лийр таньд алим байвал хуваагаад солилцход би ч алим, лийртэй, та ч алим, лийртэй болох юм.**

**Клубын цугларалт нь санал бодлоо хэлэлцэх, дасгал сургуулуулалт хийх, асуудалыг хамран шийдэх маш үр дүнтэй арга юм. Гол нь ямарч клуб өөрөө удирдах системийг мөрдлөгө болгох нь чухал. Жишээ нь: сурагчдын клубыг сурагч удирдах, оюутны клубыг оюутан удирдах гэх мэтчлэн эрх чөлөөт байх хэрэгтэй.**

### **Удирдах зөвлөлийн гишүүд**

**Мөн клубт зөвлөх байж болох бөгөөд клубын зохион байгуулалт хэсэгт тодорхой өгүүлэх болно.**

**Бусад байгууллагаас ялгагдах онцлог бол ямарч төрөлийн бүтэц, зохион байгуулалтын хэлбэрийг сонгож болдог. Тэр ч бүү хэл ямар нэгэн зохион байгуулагчгүй байсан ч болдог. Гагцхүү үйл ажиллагаа нь тодорхой байх хэрэгтэй.**